ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын зургаадугаар хавсралт

# ЗАХИАЛГЫН ХУУДАС

**Огноо:** 2024.04.13 **Дугаар:** 554-02-02-7.19.2.1.11

**Нэгж:** Хүний нөөцийн хөгжил, сургалтын хэлтэс

| № | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Зориулалт | Техникийн тодорхойлолт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Оосорлогч дохиочны эрх олгох сургалт | Хүн | 70 | Албан хэрэгцээнд | Хавсралт |

# ООСОРЛОГЧ ДОХИОЧНЫ ЭРХ ОЛГОХ СУРГАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

<table>
<tr><th>№</th><th colspan="2">АГУУЛГА</th></tr>
<tr><td>1</td><td>Зорилго</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 10 дугаар зүйлийн 10.1 “Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна” гэж заасны дагуу Салбарын үйл ажиллагаанд өргөх, зөөх төхөөрөмж, түүний аюулгүй ажиллагаа, оосорлох тоног төхөөрөмж, хэрэгслийг аюулгүй, эрсдэлгүй ажиллуулахад холбогдох ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх, оосорлогч дохиочны эрхтэй болгох.</td></tr>
<tr><td>2</td><td>Зорилт</td><td>Сургалтын хэрэгцээнд үндэслэн чанартай, үр дүнтэй сургалтыг зохион байгуулах, холбогдох ажилтнуудыг хамруулах.</td></tr>
<tr><td>3</td><td>Хэрэгцээ, шаардлага</td><td>Тоног төхөөрөмжөөс хөдөлгүүр, хурдны хайрцаг, захын дамжуулагч, автосамосвалын дугуй зэрэг том эд ангиудыг салгаж авах, угсрах үеийн аюулгүй ажиллагааны мэдлэг дээшилж, осол аваарт нэрвэгдэх эрсдэл багасна.</td></tr>
<tr><td>4</td><td>Сэдэв</td><td>Сургалтыг дараах сэдвүүд болон шаардлагатай бусад сэдвүүдийг нэмж явуулах:<br>- Кран, өргөх төхөөрөмжийн бүтэц, ажиллах зарчим;<br>1. Кран, өргөх төхөөрөмжийн ерөнхий бүтэц, ажиллах зарчим, ангилал<br>2. Кран, өргөх төхөөрөмжийн эд ангиудын бүтэц, онцлог<br>3. Бүтэц ажиллах зарчмаар дадлагын хичээл<br>-Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа;<br>1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа<br>2. Тэмдэг тэмдэглэгээ<br>3. ХАБ-ын дадлага хичээл<br>-Оосорлогч дохиочны хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа;<br>1. Оосорлогч дохиочны аюулгүй ажиллагаа<br>2. Хөдөлмөр, хамгаалал, ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа, ачааг баглаж оосорлох, өрж хураах журам<br>3. Ачаа өргөх шилжүүлэх үед гараар өгөх дохионы төрөл, хэлбэр, хэрэглээ<br>4. Аюулгүй ажиллагаа, дохиогоор дадлагын хичээл<br>-Кран өргөх төхөөрөмжийн ашиглалт, хууль эрх зүй;<br>1. Кран өргөх төхөөрөмжийн талаарх хууль, дүрэм, стандартын тухай ерөнхий мэдээлэл<br>2. Кран өргөх төхөөрөмжийг ашиглахад оролцдог субъектүүдийн ажиллах журам<br>3. Кран өргөх төхөөрөмжийн ашиглалтаар дадлагын хичээл<br>-Бусад.</td></tr>
<tr><td>5</td><td>Хэлбэр</td><td>Онол болон практик хосолсон байдлаар</td></tr>
<tr><td>6</td><td>Тавигдах шаардлага</td><td><u>Сургалтын байгууллагад</u>:<br>• Эрх бүхий байгууллагаас тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх;<br>• Тухайн чиглэлээр 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай;<br>• Сүүлийн 3 ба түүнээс дээш жил уул уурхайн салбарт тухайн чиглэлээр сургалт явуулж байсан туршлагатай;<br>• Сургалтын хөтөлбөртэй, түүний дагуу сургалтыг явуулах;<br>• Сургалтын өөрийн анги, танхим, техник, тоног төхөөрөмжтэй, дадлага хийх боломжтой байх;<br>• Сургалтыг хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангах;</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | • Тухай сургалтын агуулга, хугацаа, хамрах хүрээ зэргээс шалтгаалан мэргэжлийн багш нартай байх;<br>• Сургалтад хамрагдсан ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх олгох.<br>• ХАБЭА-н асуудлаар мэргэшсэн багштай байх. |
| | | *<u>Сургагч багшид</u>*:<br>• Сургагч багш нь тухайн чиглэлийн мэргэжлийн бөгөөд мэргэшсэн байх;<br>• Сургагч багш нь тухайн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх;<br>• Илтгэх ур чадвар, багшлах ёс зүй хэм хэмжээг мөрддөг байх;<br>• Холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулах. |
| 7 | Хамрах хүрээ | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн НАЛХ, ТАХА, ЗМХ, ТУХХ -ийн ажилтнууд /70/ |
| 8 | Хугацаа | 2024 онд |
| | | 1-5 өдөр |
| | | 24 цаг /сургалтын агуулгаас шалтгаалан сургалтын цагийг нэмж, хасах боломжтой/ |
| 9 | Төсөв | Сургалтын танхим, сургагч багшийн цалин, сургалтын хэрэглэгдэхүүн болон бусад зардал |
| 10 | Байршил | Улаанбаатар хот |
| 11 | Үр дүн | Сургалтад хамрагдсан ажилтны мэдлэг, ур чадвар нэмэгдэж, ажлын бүтээмж өснө. |